

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

**СЭТГҮҮЛ ЗҮЙН МӨН ЧАНАР БА ТАНИН МЭДҮҮЛЭХ БОЛОМЖИЙН
ХАРИЛЦАН ХАМААРЛЫН АСУУДАЛД**

М.Зулькафиль*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн профессор, доктор (Sc.D).

Түлхүүр үгс: Танин мэдүүлэх үүрэг, эпистомологийн мэдлэг, танин мэдэхүйн онол, үнэлэмжийн үйл ажиллагаа, метаонолын объект, логикийн ба парадокс шинж

Монголын сэтгүүл зүйн судлалд сэтгүүл зүйн нийгмийн үүргийн асуудал тодорхой хэмжээгээр судлагдсан боловч үүрэг болгоныг тусгайлан гүнзгийрүүлэн судалсан бүтээл нэн ховор бөгөөд ОНМХ-ийн үүргийг түүний мөн чанартай холбон судалж, харилцан хамаарал, харилцан нөлөөллийн асуудлыг бараг судлаагүй гэж хэлж болно. Энэ өгүүлэлд анх удаа сэтгүүл зүйн танин мэдүүлэх боломжийг түүний мөн чанартай холбон тайлбарлаж, Монголын сэтгүүл зүйн танин мэдэхүйн үүрэг хангалтгүй байгаа шалтгааныг дээрх асуудлуудын хүрээнд авч үзэхийн зэрэгцээ танин мэдүүлэх үүрэгт чухал байр эзэлдэг сэтгүүл зүйн эпистомологийн мэдлэгийн талаар нэлээд дэлгэрэнгүй өгүүлж, түүний ач холбогдлыг тодорхой жишээн дээр гаргаж өгөхийг зорилго болгосон.

Ингэхдээ дээрх асуудлуудыг ажиглалт, логикийн, харьцуулан судлах, контент-анализын аргын тусламжтайгаар судалж, тодорхой үр дүнд хүрэхийг чухалчилсан болно.

Сэтгүүл зүйн нэг гол үүрэг бол танин мэдүүлэх үүрэг гэдэгтэй хэн ч маргахгүй. Сэтгүүл зүй судлаачид түүнийг мэдээлэх үүргийн дараа ордог хамгийн чухал үүргийн нэг гэж үздэг нь санамсаргүй зүйл биш бөгөөд энэ бол сэтгүүл зүйн хөгжлийн 400 гаруй, электрон сэтгүүл зүйн 100 гаруй жилийн туршлагаар батлагдсан зүйл юм. Гэхдээ манай орны сэтгүүл зүйн танин мэдүүлэх үүрэг тийм ч өндөр түвшинд биш байгааг бидний удаа дараа явуулсан судалгааны (2003, 2015) үр дүн харуулсан байдаг. Мөн сэтгүүл зүйн, тэр дундаа телевизэд танин мэдүүлэх, соён гэгээрүүлэх нийтлэл, нэвтрүүлэг маш ховор, байгаа бүтээлүүдийн чанар тааруу, ач холбогдол багатай, сэтгүүлчийн ур чадвар сул байгааг хүлээн авагчид байнга шүүмжилдэг нь ажиглагддаг. Үүнд нөлөөлж байгаа олон шалтгаан байгаагийн дотор

ХМХ-ийг эрхлэн гаргагчид түүний нийгмийн үүргийг дутуу үнэлэх, сэтгүүл зүйн мөн чанарыг хагас дутуу ойлгох, хүлээн авагчдын оюуны хэрэгцээ шаардлагыг үл харгалзах хандлага гол байр эзэлдэг. Үүний учир шалтгааныг тайлбарлахаас өмнө сэтгүүл зүйн бодит байдлыг танин мэдэх онцлогийн талаар товч өгүүлье.

Танин мэдэхүйн өвөрмөц хэлбэр болох сэтгүүл зүй хүмүүсийн нийгмийн олон талт амьдралын янз бүрийн үйл явдал, үзэгдэл, баримтын талаар цаг үеийн шуурхай мэдээлэл хүлээж авах гэсэн нийгмийн хэрэгцээ шаардлагын үндсэн дээр үүссэн түүхтэй. Сэтгүүл зүй хөгжиж, төлөвших явцад танин мэдэхүйн нэлээд хожим үеийн хэлбэр болохын хувьд арга зүйн хэрэгслүүдийг философи, шинжлэх ухаан, урлаг зэрэг бусад танин мэдэхүйн хүрээнээс зээлдэн авсан байдаг. Асуудлын гол нь энэхүү зээлдэн авсан зүйлийн шинж чанарт оршиж байв. Учир нь чухам түүний үндсэн дээр сэтгүүл зүй өөрийнхөө арга хэрэгслийг боловсруулж чадах учиртай байлаа. Энэ асуудал өнөөдөр хүртэл өөрийнхөө ач холбогдлыг алдаагүй бөгөөд эсрэгээр бүр тулгамдсан асуудлын нэг болж хувирсан хэвээр байна.

Орчин үед туршилтын, урсгал шинжтэй зөн билгийн сэтгүүл зүйн үе аль хэдийд өнгөрснийг бид мэднэ. Сэтгүүл зүйн онолын түвшинд арга зүйн шинэ хөтөлбөрийг боловсруулахыг шаардаж байгаа бөгөөд практик сэтгүүлчид түүнд хандах замаар хүмүүсийн өдрөөс

өдөрт өөрчлөгдөж нарийн төвөгтэй болж байгаа нийгмийн амьдралыг таньж мэдэх шинэ боломж олж авах учиртай юм. Энэ хандлага ялангуяа Өрнөдийн эрдэмтдийн боловсруулсан социо-сэтгүүл зүйд улам тод ажиглагдах болжээ. Хэрэв сэтгүүл зүйн онол шинжлэх ухааны салбар мөн юм бол өөрийн гэсэн шинжлэх ухааны үндэслэлтэй арга зүйг боловсруулах, судалгааны объект ба судлагдахууныг тодорхойлох, шинжлэх ухааны категориудын зөрчилгүй нэгдмэл системийг бий болгох ёстой. Манай орны сэтгүүл зүйн өнгөрсөн үеийн түүх шинжлэх ухааны болон утга зохиолын хүрээнд үүсэж, хөгжиж ирсэн нь зарчмын хувьд зөв чиглэл байсныг илэрхийлдэг. Сэтгүүл зүй одоо ч хэл бичиг, утга зохиол, социологи, сэтгэл судлал зэрэг янз бүрийн шинжлэх ухаантай ямар нэг хэмжээгээр харилцаа холбоотой оршдог. Бид сэтгүүл зүй тэдний арга зүйн хэрэгсэл, чиг баримжаанд тодорхой хэмжээгээр түшиглэдэг гэдгийг дээр хэлсэн. Гэхдээ тэдний судлагдахууны салбарт тэр чигээр нь уусаж алга болоогүй, ирээдүйд ч болохгүй гэдэг нь ойлгомжтой. Учир нь сэтгүүл зүй өөрийн гэсэн давтагдашгүй онцлог, мөн чанарыг агуулдаг. Сэтгүүл зүй бол нэг талаар, шинжлэх ухаан, урлагийн нэгэн адил нийгмийн танин мэдэхүйн нэг хэлбэр, нөгөө талаар, хүний уран бүтээлийн өвөрмөц төрөл мөн. Чухам энэхүү хосолмол шинжид түүний мөн чанар оршдог.

Сэтгүүл зүй нийгмийн үзэгдэл болохын хувьд бие даасан, нэгдмэл

зүйл бөгөөд шууд утгаар нь шинжлэх ухаанд ч, урлагт ч хамааруулах нь учир дутагдалтай. Тэгсэн мөртлөө нийгмийн танин мэдэхүйн эдгээр хэлбэрүүдийн аль алины тодорхой шинж чанар, онцлогийг өөртөө агуулдаг. Шинжлэх ухааны онолын болон эмпирик хэсгүүдийг авсан бол практик сэтгүүл зүй тодорхой хэмжээгээр урлаг руу ойртдог. Оросын судлаач Л.Г.Свистич сэтгүүл зүйг мэдээллийн парадигмын хүрээн дэх танин мэдэхүйн үзэгдэл гэж үзээд түүнийг философийн категориудтай болон танин мэдэхүйн хэв маяг болох философитой адилтгаж үзэх нь зөв гэсэн дүгнэлт хийсэн байдаг. Судлаач үүнтэй холбогдуулан: “Хэрэв философийг хүн ба ертөнцийн хувьсал хөгжлийн мөн чанарын танин мэдэхүй мөн гэж, сэтгүүл зүйг өнөөдрийн бодит байдлын, нийгмийн цаг үеийн амьдралын, түүнд орших хүний амьдралын тусгал гэж ойлгох юм бол сэтгүүл зүйг орчин цагийн философи, өдөр тутмын амьдралын философи, тухайн цаг мөчийн философи, бодит нөхцөл байдлын философи... гэж ёс төдий нэрлэж болно” гэж тэмдэглээд тодорхой, нүдэнд харагдахуйц, хөдөлгөөнт гадаад ертөнцийг сэтгүүл зүйн танин мэдэхүйн судлагдахуун мөн гэж үзсэн байдаг (Стивич, 2000).

Судлаачид сэтгүүл зүйн болон философийн танин мэдэхүйг харьцуулахад гол үндэслэл болгон “бодит байдлыг танин мэдэх түгээмэл хэлбэрүүдийн дотроос хамгийн тодорхой, хамгийн эмпирик шинжтэй нь сэтгүүл зүй мөн. Сэтгүүл зүйн

философийн хийсвэр танин мэдэхүйгээс ялгаа нь бодит байдлыг таньж мэдэх энгийн бөгөөд ерөнхий арга” (Стивич, 2000) гэсэн дүгнэлт юм.

Орчин үеийн философичид танин мэдэхүйн сонгодог ерөнхий онол нь “философийн түүхэнд зарим хийсвэр ойлголтын хувьд төлөвшсөн” гэж үздэг. Ингэхдээ танин мэдэхүйн ерөнхий онолын гадуур иррациональ, шинжлэх ухаанч бус, “өөр шинжлэх ухааны” мэдлэгийн асар том салбар үлдсэн байдаг. Өөрөөр хэлбэл танин мэдэхүйн анхаарлын төвд байх, судлагдахуун болох ёстой маш олон зүйл үлдсэн гэсэн үг. Гэхдээ тэд танин мэдэхүйн анхааралд өртөж чадаагүй нь байгалийн шинжлэх ухааны мэдлэгийн үнэн бодитой байх шалгуурт нийцээгүй юм (Российский энциклопедический словарь).

Энэхүү “шинжлэх ухаанч бус” шинжтэй асар их мэдлэг танин мэдэхүйн сонирхлын хүрээний гадуур үлдсэн нь олон асуултад хариулт өгөх боломжийг хязгаарлаж танин мэдэхүйн онол өөрөө явцуурч, ядуурахад хүргэжээ. Орчин үеийн танин мэдэхүйн онол танин мэдэхүй дэх рациональ ба иррациональ асуудлуудыг, тэдний харьцаа, хэв маягийг шинээр авч үзэх, эргэж харах замаар “уламжлалт танин мэдэхүйн онол дахь сонгодог байгалийн шинжлэх ухааны болон рационализмын үзэл санааны ноёрхол”-ыг арилгахыг оролдож байна. Эрдэмтдийн бодлоор өнөөдөр “логик хүртэлх, ойлголт хүртэлх мэдлэг, мэдлэг ба ойлголтын

орхигдсон, анхаарлын гадна үлдсэн асуудлууд” (Российский энциклопедический словарь) танин мэдэхүйн онолын судлагдахуун болж байна. Орчин үеийн танин мэдэхүйн онол өөрийнхөө хөгжлийн явцад танин мэдэхүйн тухай орчин үеийн тусгай шинжлэх ухаануудын философийн болон арга зүйн үндэс болох замаар тэдний баримт мэдээллийг өргөн ашиглах болжээ.

Энэ бүхнээс үзэхэд орчин үед “гносеологи” хэмээх ойлголтыг “танин мэдэхүйн зүй тогтол ба боломж, мэдлэг ба бодит байдлын харилцаа, танин мэдэхүйн үйл явц, нөхцөл ба түүний үнэн бодитой байх шалгууруудыг судалдаг философийн салбар” (Российский энциклопедический словарь) хэмээн тайлбарласан бол өөр нэг философийн толь бичигт гол анхаарлаа “танин мэдэхүйн үйл ажиллагааны явц дахь субъект ба объектын харилцаа холбоо, мэдлэг ба бодит байдлын харилцаа, хүний ертөнцийг танин мэдэх боломж, мэдлэгийн үнэн бодитой байх шалгуурт” (Философский словарь, 1972) хандуулсан байдаг.

Эртний философичид танин мэдэхүйн аливаа юмны бодит мөн чанарыг тодруулахад чиглэгдсэн

онолын, аливаа юмны өөрчлөлтийг тодруулахад чиглэгдсэн практикийн гэж хоёр ангилсан байдаг. Орчин үед танин мэдэхүйн онолд бодит байдлыг танин мэдэх шинжлэх ухааны, ердийн, уран сайхны болон бусад танин мэдэхүйн төрөлжсөн хэлбэртэй гэж үздэг байна.

Хэрэв дээрх дүгнэлтийг иш үндэс болговол сэтгүүл зүйг төрөлжсөн танин мэдэхүйд хамааруулах

боломжтой бөгөөд түүнд шинжлэх ухааны, ердийн, уран сайхны зэрэг янз бүрийн хэлбэрүүд нэлээд нарийн төвөгтэй харилцан хамааралд оршдог нь тодорхой юм. Энэхүү танин мэдэхүйн хэлбэрүүдийн нэгдлийн ачаар сэтгүүл зүй хүний өдөр тутам учирдаг бодит байдлын талаарх төсөөллийн системийг шуурхай

«
Сэтгүүл зүйг төрөлжсөн танин мэдэхүйд хамааруулах боломжтой бөгөөд түүнд шинжлэх ухааны, ердийн, уран сайхны зэрэг янз бүрийн хэлбэрүүд нэлээд нарийн төвөгтэй харилцан хамааралд оршдог нь тодорхой юм. Энэхүү танин мэдэхүйн хэлбэрүүдийн нэгдлийн ачаар сэтгүүл зүй хүний өдөр тутам учирдаг бодит байдлын талаарх төсөөллийн системийг шуурхай илэрхийлж, төлөвшүүлж чаддаг.
»

илэрхийлж, төлөвшүүлж чаддаг. Юуны өмнө сэтгүүл зүйн ертөнцийг, хүрээлж буй орчныг гносеологийн үүднээс таньж мэдэх өвөрмөц онцлог нь юунд орших вэ гэдгийг тодруулж, танин мэдэхүйн суурь хэлбэрүүдийг тодорхойлохыг оролдъё.

Эрдэмтэн судлаачид “шинжлэх ухааны танин мэдэхүй бодит байдлын судлагдахуун ба үзэгдлийн

зан үйлийн хуулиудыг илүүлэхэд чилэгдсэн байдаг бөгөөд энэхүү зан үйлийг хүний хэрэгцээ, сонирхолд нийцэхүйц чиглэлд өөрчлөх хамгийн үр ашигтай, оновчтой аргуудыг төлөвшүүлэх зорилготой юм. Энэхүү нөхцөл нь хүмүүсийн үйл ажиллагааны ирээдүйн боломжтой үр дүнг таамаглах найдвартай арга замыг, хэрэгцээг бий болгодог” (Липского, 2000) байна. Танин мэдэхүйн онолын хэлбэр бол судалж буй бодит байдлын мөн чанарыг нэлээд тодорхой түвшинд илэрхийлэхэд чиглэгдсэн байдаг. Тиймээс асуудлын гол нь бодит байдлыг тодорхойлон тайлбарлахад бус, энэхүү бодит байдлын ажиллагааг тодорхойлдог хуулиудын системийг бүтээхэд оршино.

Ердийн танин мэдэхүйн онцлог нь үйлдлийн уламжлалт болон мэдээжийн аргуудыг үргэлж хадгалахад чиглэгдсэн байдаг. Учир нь тэд өмнөх олон жилийн туршид үргэлж үр ашигтай гэдгээ харуулж чадсан юм. Ердийн танин мэдэхүйн хамгийн гол онцлог шинжүүдийн нэг бол “ирээдүйд чиглэгдсэн сонирхол маш бага. Практик зорилтуудын тодорхой байх боломжийг тэднийг шийдвэрлэх явцад үүссэн мэдлэг хязгаарлаж байдаг. Учир нь ердийн практик бол аль хэдийд тодорхой мэдээжийн үр дүнд хүрэхийг чухалчилдаг. Үнэн хэрэг дээрээ тэр хүсэн хүлээж буй зүйл нь алдаатай байх магадлалтай юм” (Липского, 2000).

Ертөнцийг уран сайхны аргаар танин мэдэхүй гол төлөв хүний мэдрэмжийн хүртэхүйд суурилагд-

сан байдаг. Чухам үүнээс хөгжим, уран зохиолын дүр, уран зураг зэрэг уран сайхны танин мэдэхүйн өвөрмөц бүтээгдэхүүнүүд бий болдог.

Хэрэв шинжлэх ухаан объектив, социал бодит байдлыг танин мэдэх хэлбэрийн хувьд байгаль, нийгэм, хүний тухай шинэ мэдлэгийн үйлдвэрлэл бол урлаг уран сайхны дүр бүтээх замаар ертөнцийг гоо зүйн үүднээс эзэмших явдал юм. Тэгвэл сэтгүүл зүйн үндсэн зорилго нь цаг үеийн бодит байдлыг түүний бүхий илрэлд нь шуурхай танин мэдэхэд оршино. Ингэхдээ нийгмийн танин мэдэхүйг гносеологийн үүднээс судлах явдал нийгмийн ба хувь хүний ухамсар болон тэднийг тусгах объектын хоорондох харьцаанд дүн шинжилгээ хийхэд үндэслэгдсэн байдаг. Энд судлаач анхаарлаа хамгийн түрүүнд нийгмийг танин мэдэх үйл явц яаж явагддаг вэ, тусгах аргын үүднээс авч үзвэл тэдний хэлбэрийн өвөрмөц онцлог юунд орших вэ, үнэнд хүрэхэд ямар арга хэлбэрийг ашиглах вэ, түүний шалгуур нь юу байх вэ гэсэн асуултуудад хандуулдаг. Өөрөөр хэлбэл, нийгмийг танин мэдэхүйг гносеологийн үүднээс судална гэдэг бол зарчмын хувьд нийгмийг танин мэдэхтэй холбоотой танин мэдэхүйн онолын үндсэн асуудлуудыг авч үзнэ гэсэн үг юм.

Танин мэдэхүйн онолыг тусгалын онолтой адилтган үзэж ирсэн уламжлалтай. Тусгалын онол он удаан жилийн туршид танин мэдэхүйн онолын үндсийг бүрдүүлж ирсэн түүхтэй. Зарим судлаач тусгалын энгийн төрөлд хүн биеэрээ

мэдрэх тусгалыг багтаасан бөгөөд үүний тод жишээ бол дуу чимээ болон гэрлийг тусгах явдал мөн юм.

Тусгал ба танин мэдэхүй хоёр үүрэг, зорилгын хувьд хооронд нэлээд төстэй бөгөөд тэдний хамгийн гол нийтлэг шинж бол хүрээлж буй бодит байдалтай хандах харилцаа юм. Тусгах үйл явцад тусгалын мөр буюу бодит байдлын талаар янз бүрийн шинэ төсөөлөл хуримтлагддаг. Хүний танин мэдэх үйл ажиллагаанд ч яг ийм зүйл явагддаг. Гэхдээ бие хүний хүрээлж буй бодит байдалтай харилцан нөлөөлөл, хандлага нь арай өргөн хүрээтэй, олон янзын шинжтэй байдгаараа ялгаатай юм. Бие хүн объект-субъектийн харилцаанд нэг талаар, объектыг таньж мэддэг (хүний танин мэдэх үйл ажиллагаа хэрэгждэг), нөгөө талаар, объектыг янз бүрийн дүрд хувиргаж үнэлэх замаар түүнийг өөрийнхөө ухамсарт тусгадаг. Харилцааны энэ төрлүүдийн үндсэн дээр хүний үйл ажиллагааны танин мэдэхүйн, үнэлэмжийн, өөрчлөн тусгах зэрэг үндсэн төрлүүд бий болдог.

Уран бүтээлч хүн танин мэдэх үйл ажиллагааны явцад объект ба субъектийн, хувь хүний ба нийгмийн хоорондох олон янзын харилцааны “талбарт” бий болдог хүний үйл ажиллагааны янз бүрийн төрлийг нэгэн зэрэг гүйцэтгэх болно. Энэ бол:

- Танин мэдэхүйн үйл ажиллагаа. Үүний үр дүнд уран бүтээлч объектив бодит байдлыг тусгаж, түүхийн тодорхой эрин болгон дахь

бие хүн ба нийгмийн хоорондох харилцаа холбоог танин мэддэг.

- Өөрчлөн тусгах үйл ажиллагаа. Уран бүтээлч үйл ажиллагааны явцад бүтээж буй дүрд байгалийн материалыг (будаж, хэлбэр, дуу чимээ г.м.) болон хүн ба нийгмийн амьдралын материалыг өөрчлөн тусгадаг. Ингэхдээ тэр материалыг янз бүрийн өгүүлэмж, зохиомжийн харилцаанд, заримдаа зохиогчийн үзэл баримтлалд тохируулан орон зай, цаг хугацааны холбоонд ч өөрчлөн хэрэглэдэг.

- Хүмүүжлийн үйл ажиллагаа. Энэ нь хүлээн авагчдын оюуны ертөнцөд нөлөөлөх гэсэн хүчин чармайлтаар илэрхийлэгддэг.

- Үнэлэмжийн үйл ажиллагаа. Уран бүтээлч энэ үйл ажиллагааны ачаар үйл явдлыг өөрийнхөө сонирхол, хэрэгцээ, туйлын зорилго, таашаалд нийцүүлэн тусгах замаар мэдрэмж, үнэлэмжээ илэрхийлдэг.

- Харилцааны буюу уран бүтээлч өөрийнхөө бүтээлийг хүлээн авагчидтай шууд ба дам харилцах үйл ажиллагаа юм.

Энэ бүхнээс үзэхэд бодит байдлын объектыг танин мэдэх уран бүтээлийн тал нь зөвхөн аливаа объектын тодорхой шинжийг мэдэхэд төдийгүй ямар нэгэн шинэ юмыг бүтээхэд оршдог байна. Ингэхдээ шинэ зүйл нь тусгах явцад ч, эсвэл бүтээлд ч бий болох боломжтой юм. Тэдний ялгаа нь тусгах явцад бий болсон шинэ юм тусгаж буй зүйлийг чанарын хувьд бус зөвхөн тооны хувьд өөрчлөхөд оршино. Бүтээлч үйл ажиллагааны явцад тусгах ба харилцан нөлөөл-

лийн үндсэн дээр үүссэн шинэ юм чанарын хувьд шинэ объектыг эсвэл үйл явцыг бий болгодог ажээ.

Сэтгүүлч нийгмийн бодит байдлыг танин мэдэх үйл явцад зөвхөн объектын ямар нэгэн шинж тэмдгийг судлахын зэрэгцээ түүний бүх гол шинжүүдийг өөрийнхөө оюун санаанд тусгах замаар түүнд нөлөөлөхийг чухалчилдаг. Сэтгүүлчийн танин мэдэх үйл ажиллагаа нь ямагт нийгмийн бодит байдлыг ерөнхийд нь төсөөлөн бодоход чиглэгдсэн байдаг. Үүний онцлог шинж нь танин мэдэх үйл явцад сэтгүүлчид бодит байдлыг практик талаас нь мэдрэх, хүмүүсийн туршлага, ердийн практик ухамсрыг ойроос мэдрэх нь чухал ач холбогдолтой байдаг оршино. Үүнээс сэтгүүлчийн танин мэдэх үйлдлийн ямар ч хэлбэр нь хүмүүсийн практик үйл ажиллагаанаас урган гарсан бөгөөд өөрийнхөө хөгжлийн бүхий явцад материаллаг практикт үйлчилж ирсэн байдаг. Сэтгүүлчийн бүтээлүүдэд хүний оюуны болон практик үйл ажиллагааны үр дүн хуримтлагдсаны хамт хүний хичээл зүтгэлийн туршлага, ирээдүйд гэсэн хүсэл тэмүүлэл тусгалаа олсон байдаг. Тиймээс сэтгүүлч нийгмийн бодит байдлын янз бүрийн объектуудыг танин мэдэх явцад зөвхөн олсон баримтуудыг мэдээлэх, тэдний нийгмийн туршлагад нийцэж байгаа эсэхийг тодруулах төдийгүй үнэлэх, нийгмийн ач холбогдолтой, хэрэгтэй эсэхийг бүх талаар тунгаан бодох, эцэст нь хүний харилцааны хөгжил дэх шинэ хандлагыг олж харахыг чухалчилдаг.

Сэтгүүлчийн танин мэдэхүйн төвд ямагт нийгэмд явагдаж буй хөдөлгөөнт үйл явцууд байдаг. Сэтгүүлчийн үйл ажиллагаа нь нийгмийн янз бүрийн тулгамдсан асуудлуудыг агуулж буй нөхцөл байдал, нийгмийн зөрчлийг судлах, нийгэм-улс төрийн, эдийн засгийн, ёс суртахууны нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэх арга замыг эрж хайх, түүнд дүн шинжилгээ хийх, үр дагаврыг таамаглахад чиглэгддэг нь чухам үүнтэй холбоотой юм.

Сэтгүүлчийн танин мэдэх ажиллагааны өвөрмөц онцлог нь мөн чанарын хувьд синтетик шинжтэй буюу нийгэм, ертөнцийг шинжлэх ухааны, уран сайхны, туршилтын аргуудын харилцаан нөлөөллийн үр дүнд эзэмшихэд оршино. Сэтгүүлчийн бүтээлч ажиллагаанд шинжлэх ухааны онол, практикийн судалгааны нэгэн адил задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, индукц ба дедукц, хийсвэрлэх, загварчлах, харьцуулах, адилтгал, тодорхойлох зэрэг танин мэдэхүйн ерөнхий онолын аргуудыг эзэмших нь онцгой чухал үүрэгтэй. Чухам дээрх аргуудын үндсэн дээр ойлголтуудыг томъёолох, эргэцүүлэн бодох, оюун дүгнэлт хийх үйл явц хэрэгждэг онцлогтой.

Энэ бүхнээс үзэхэд нийгмийг танин мэдэх хэлбэр болох сэтгүүл зүйн мөн чанар нь бодит байдлыг рациональ ба уран сайхны аргын нэгдлийн ачаар эзэмшихэд оршино. Сэтгүүл зүй энэхүү шинжлэх ухааны болон уран сайхны аргуудыг хослон хэрэглэх замаар бодит байдлыг таньж мэдэх, эзэмших, тусгах өвөр-

мөц шинжийг агуулах болсон. Энэ бол зөвхөн сэтгүүл зүйд байдаг онцлог шинж юм. Сэтгүүлчийн танин мэдэх бүтээлч үйл ажиллагааны онцлог нь зөвхөн ямар нэгэн объектыг таньж мэдэх төдийгүй мэдээллийн шинэ бүтээгдэхүүнийг бий болгоход оршино.

Дээр өгүүлснийг үндэслэн сэтгүүл зүйн метаололын объект нь нийгмийн үзэгдэл (феномен) болох сэтгүүл зүй, түүний судлагдахуун нь сэтгүүл зүйн танин мэдэх бүтээлч шинж (мөн чанар) мөн гэсэн дүгнэлт хийж болно. Арга зүйн болон уран бүтээлийн шинжтэй бүх асуудлууд чухам үүнээс урган гарсан байдаг. Арга зүйн асуудлууд нь нийгмийн бодит байдлыг танин мэдэх үйл явцтай, уран бүтээлийн асуудлууд нь түүнийг тусгах хэлбэртэй холбоотой юм. Үүнтэй холбоотой сэтгүүл зүйн эпистемологийн асуудлуудыг хөндөх шаардлага зайлшгүй тулгардаг.

Эпистемологи бол үр дүн нь мэдлэг болох танин мэдэхүйн үйл явцын ерөнхий шинжүүдийг судалдаг философийн салбар юм. “Эпистемологи” хэмээх нэр томъёо эртний грекийн *episteme*—“мэдлэг” гэсэн үгнээс гаралтай ажээ.

Сэтгүүл зүй ертөнцийн тухай ямар мэдлэгийг яаж боловсруулдаг вэ? Тэдний үндсэн дээр ертөнцийн ямар дүр зураг бий болдог вэ? Энэ мэдлэг хэр зэрэг үнэн бодитой вэ? Бидний сэтгүүл зүйн эпистемологийн асуудлуудад хандах шалтгаан нь чухам эдгээр асуултад хариулт эрж хайхтай холбоотой юм.

Хэрэв бид сэтгүүл зүй бол нийгмийн танин мэдэхүйн нэг хэлбэр болох статус нь эргэлзээтэй гэж үздэг зарим эрдэмтний үзэл бодолд хандахгүйгээр дээрх асуултуудад хариулах боломжгүй юм. Тэдний ингэж үзэх гол үндэслэл нь ОНМХ-ийн ихэнх эх бичвэрт “эпистемологийн туйлын зорилгод” үл нийцэх зүйл олон байгаатай холбоотой ажээ. Бодит байдлыг янз бүрийн аргаар тусгасан эх бичвэрүүд, агуулгаараа аль нэг соёлыг илэрхийлсэн дүр ба бэлгэдлүүд, өдөр тутмын үйл явдлын урсгалаас авсан бодит ба хуурамч баримтууд зэрэг маш олон зүйлээс сэтгүүл зүйн ертөнцийн дүр зураг бүрддэгийг бид мэднэ. Түүнд хандсан хүн болгон ертөнцийн тухай үнэн бодитой мэдлэг авч чадах уу? Үүнд нэг утгатай төгс хариулт өгөх боломжгүй гэдэг нь тодорхой. Нэг талаар, хүмүүс сэтгүүл зүйн бүтээсэн ертөнцийн дүр зургийн ачаар өдөр тутмын амьдралд чиг баримжааг олж авах боломжтой, нөгөө талаар, бодит байдалтай ямар ч хамаагүй өөр орчин руу явах магадлал ч өнөөдөр байдаг. Судлаачдын бодлоор нийгмийн харилцааны сувгуудаар дамжин ирж буй ертөнцийн мэдээллийн дүр зураг ихээхэн өөрчлөгдсөн байдаг бөгөөд энэ нь түүний тусламжтайгаар хувь хүний ухамсарт төлөвшиж буй ертөнцийн дүр зурагт хүчтэй нөлөөлдөг байна. Энэхүү өөрчлөлт нь дараах байдлаар илэрдэг нь түгээмэл юм.

- Ёс зүйн болон гоо зүйн үнэт зүйлсийн чиг баримжааг алдах;

- Мэдлэг үнэ цэнээ алдах, мэдлэг ба мэдээллийг ялгах чадваргүй болох;

- Өөрийн үнэлэмж болох мэдлэгийн тухай ойлголтыг бэлэн хэрэгсэл болох мэдлэгийн тухай ойлголттой хольж хутгах;

- Ямар ч ач холбогдолгүй энгийн, бүдүүлэг хийсвэр загвар, үг хэллэгүүдийг нэвтрүүлэх. Тухайлбал, үүний үр дүнд хэл ярианд хэрэглэж буй ихэнх хүний хувьд ямар ч утгагүй олон үг бий болж, энэ нь хүмүүсийн хоорондох харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг.

- Ахуйн дээд түвшний илрэлд хандах мэдрэмжээ алдсанаас сэтгэхүйн зүүн бөмбөлгийн хэлбэр давамгайлах;

- Нийгмийн харилцааны сувгийн олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд шууд авч хэрэглэж болохуйц асар их хэмжээний бэлэн дүрээр дүүрсэн нь бие дааж дүр бүтээх сэтгэл зүйд чөдөр тушаа болох зэрэг юм.

Энд асуудлын гол нь зөвхөн мэдээллийн орчны бохирдолд биш, харин сэтгүүл зүй бодит баримт ба үйл явдлыг байгаагаар нь тусгадаг өдөр тутмын амьдралын толь болох утгыг алдахад байгаа юм. Сэтгүүл зүйн эпистемологийн буюу олон нийтэд ертөнцийн тухай үнэн бодитой мэдээлэл өгөх мөн чанарын тухай асуудал чухам үүнээс урган гардаг. Үүнтэй холбоотой орчин үеийн сэтгүүл зүй ямар мэдлэгийн нийлбэрийг өгч чадах вэ, мэргэжлийн хүмүүс өөрсдийн үйл ажиллагаанд ямар танин мэдэхүйн практикийг ашиглаж байна вэ, сэт-

гүүл зүйн танин мэдэхүйд баримт, мэдээлэл, мэдлэг хэмээх ойлголтууд ямар харилцаа холбоонд орших вэ, сэтгүүлчдийн ертөнцийг таньж мэдэх ойлголтын бүтэц ямар байх вэ, тэдний ажилд ургуулан бодох элемент ямар ач холбогдолтой вэ зэрэг асуултууд хамгийн чухал тулгамдсан асуудал болж байна.

Судалгааны бүтээлүүдэд сэтгүүл зүйг шинжлэх ухааны бус танин мэдэхүйн төрөлд оруулсан нь түгээмэл тааралддаг. Учир нь энд бодит байдлыг танин мэдэх рациональ буюу логик шинжээс гадна мэдрэмжээр ойлгох, хүлээж авах явдал чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс эрдэмтэд “бодит байдлыг тусгах, таньж мэдэх сэтгүүл зүйн хандлага бол шинжлэх ухааны хандлагаас үргэлж дүрслэн бодох болон логик санаачилгын, “эрүүл ухааны” баримтуудын, зөн билэг ба нарийн логикт үндэслэгдсэн байдгаараа ялгаатай. Үүний үр дүнд сэтгүүлчийн бүтээлд тусгасан баримтууд сэтгэлийн хөдөлгөөнөөр хандсан, өөрөөр хэлбэл субъектив шинжтэй юм. Угаасаа бидний ухамсарт объектив ертөнцийг субъектив хандлагаар “унших” явдал байгалиас заяасан байдаг” (Мансурова.В.Д, 2002) гэж тэмдэглэсэн нь бий. Сэтгүүлчийн танин мэдэх үйл ажиллагаан дахь дүрслэн бодох болон логикийн нэгдэл нь рациональ ба иррациональ, формаль ба уран бүтээлийн, логикийн ба парадокс шинжийн харьцаагаар тодорхойлогдоно.

Танин мэдэхүйн рациональ хэлбэр нь сэтгүүлчийн арга зүйн

хэрэгслүүдийг боловсруулах, өргөжүүлэх, судалгааны (тухайлбал, эрэн сурвалжлах сэтгүүл зүйг хэлж болно) дэс дарааллыг оновчтой зохион байгуулах ажлаар илэрдэг бөгөөд энэ нь найдвартай, үнэн бодитой мэдээлэл олж авахад тусалдаг. Танин мэдэхүйн иррациональ хэлбэрт янз бүрийн таамаглал, хувилбар, ургуулан бодсон зүйл, төсөөлөл, виртуал орчин зэргийг багтааж болно. Энэ нь сэтгүүлч ихэнх тохиолдолд танил биш, шинэ нөхцөлд ажилладаг. Сэтгүүлчид мэдээллийн зарим эх сурвалжид нэвтэрч чадахгүй тохиолдолд үйл явдлын янз бүрийн хувилбар, таамаглал дэвшүүлэх шаардлага тулгардаг бөгөөд тэдний ихэнх нь буруу байдаг нь түгээмэл юм. Бодит байдлыг тусгахдаа алдаа гардаг нь үүнтэй холбоотой юм.

Бодит байдлыг танин мэдэх формаль хандлага гэдэг нь болсон үйл явдлыг маш тодорхой тусгах зорилготой юм. Гэхдээ сэтгүүл зүйд мэргэжлийн хүн нийгмийн амьдралын аль нэг талыг тодорхой тусгахын зэрэгцээ түүнийг бүтээлчээр эргэцүүлэн бодох, дотоод мөн чанарт нь нэвтрэн орохыг чухалчилдаг.

Бүтээлч хандлага гэж тухайн объектыг тусгах хэвшил болсон арга барилаас тодорхой хэмжээгээр татгалзах, үйл явдалд өөр, шинэ өнцгөөс хандахыг чухалчлах, сэтгүүлч тулгарч байгаа зорилтуудыг стандарт бус аргаар шийдвэрлэхийг хэлдэг.

Сэтгүүлчид шинэ мэдлэг олж авахын тулд индукц, дедукц,

харьцуулалт, адилтгал, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх зэрэг шинжилгээний логикийн аргуудыг ашигладаг бөгөөд энэ нь аливаа асуудал, гол санааг ямар ч зөрчилгүй батлахад тусалдаг. Үүний яг эсрэгээр парадокс буюу ер бусын чөлөөт хандлага индуктив эсвэл дедуктив нарийн зохион байгуулалтыг үл харгалздаг. Энд логикийн хуулиуд, шалтгааны гинжин хэлхээ зэргийг санаатайгаар зөрчдөг. Мэдлэгийг “логикийн бус” аргаар боловсруулахын бааз нь сэтгүүлчийн магадлал бүхий санаа бодол, зөн билэг, таамаглал болдог онцлогтой. Гэхдээ туршлагаас үзэхэд жинхэнэ мэргэжлийн хүний аливаа үйл явдлын өрнөл, хэтийн төлөвийн талаар дэвшүүлсэн хувилбар нь “өөрчлөгдөхгүй үнэн”-тэй харьцуулахад үнэнд ойртдог нь түгээмэл юм.

Сэтгүүл зүйн танин мэдэхүйн хэв маяг нь үндсэн шинж нь системгүй, өнгөцхөн, зөрчилтэй, өөрийнхөө төсөөлөлд шүүмжлэлгүй ханддаг, зогсонги, хэвшмэл байдаг олон нийтийн ухамсар хэмээх ухамсрын өвөрмөц хэлбэрт үйлчилдэг.

Сэтгүүл зүйн “үйлдвэрлэдэг” мэдлэгийг бүхэлд нь авч үзвэл системгүй шинжтэй байдаг онцлогтой. Энд шинжлэх ухааны мэдээллийн зэрэгцээ ердийн өдөр тутмын баримтыг түгээмэл ашигладаг. Сэтгүүлчид хүлээн авагчдын сонирхлыг татахын тулд бодит байдлыг уран сайхны аргаар гоёж чимэх нь энгийн үзэгдэл. Бүр асуудал дэвшүүлсэн шинжлэлт нийтлэлүүдэд хүртэл дүгнэлт, оюун дүгнэлтүүд нь судал-

гааны үр дүн биш, амьдралын туршлага, “эрүүл ухааны” үндсэн дээр хийгдсэн байдаг нь цөөнгүй тааралддаг.

Сэтгүүл зүйн мэдлэгийн өөр нэг шинж бол түүний материаллаг зүйлтэй холбоотой байх явдал юм. Сэтгүүлчийн юуны тухай бичсэн ч тусгаж буй үзэгдлийн материаллаг мөн чанарыг илрүүлэхэд гол анхаарлаа хандуулдаг. Өөрөөр хэлбэл, тэд юуны өмнө хүмүүсийн материаллаг үйл ажиллагааны мөн чанарыг илрүүлэх, материаллаг ертөнцийн деталиудад хандахыг чухалчилдаг. Энэ бүх мэдлэг хүмүүст материаллаг орчинд зөв чиг баримжаагаа олж авахад тусалдаг.

Сэтгүүл зүй хүмүүсийн оюуны хүрээнд нэвтрэх тусам хүмүүсийн өдөр тутмын амьдралын талаар түүний оюун санааны хөгжил дэвшил, уналт ухралт, ололт амжилт ба гэмт хэрэг, амьдралын учир утгыг эрж хайх, алдаж онох зэрэг бүхий зүйлийг өөртөө агуулсан маш олон янзын мэдлэгийн нийлбэрийг бий болгодог. Энэхүү сэтгүүл зүйн бүх мэдлэгийн нийлбэрийг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

Нэгдүгээр бүлгийг янз бүрийн аргуудын тусламжтайгаар олж авсан баримт мэдээллийг тунгаан бодох, боловсруулах үндсэн дээр үүссэн мэдлэг бүрдүүлдэг бөгөөд энэ бүлгийн материалуудын үнэн бодитой байх зэрэглэл нь өндөр байдаг. Энэ тохиолдолд сэтгүүлчид идэвхтэй хөдөлмөрийн үр дүнд олж авсан баримтуудыг боловсруулдаг тул нарийн дүн шинжилгээ хийдэг.

Мэдлэгийн хоёрдугаар бүлэг нь сэтгүүлчийн шинжлэх ухаан, онолын утга санаанаас үл хамаарах хувийн туршлагад үндэслэгдсэн байдаг. Гол эх сурвалж нь хүний амьдралын туршлага, сэтгэгдэл бол-дог тул энд рациональ зүйлээс илүү зохиогчийн мэдрэмж давамгайлдаг. Амьдралын практик мэдлэг нь хүмүүсийн олон үе дамжин хуримтлагдсан нийгмийн туршлагаас эхтэй учраас тэд объектив шинжтэй байдаг нь түгээмэл юм.

Мэдлэгийн гуравдугаар бүлэгт сэтгүүлчийн амьдрал дахь өөрийн ухамсар, өөрийн танин мэдэхүйн үр дүн багтдаг бөгөөд энд ямагт субъектив шинж давамгайлдаг. Учир нь тийм мэдлэгийн эх сурвалж нь зохиогчийн өөрийн санаа бодол, эргэцүүлэл байдаг юм.

Хэрэв бид эпистемологийн үүднээс авч үзвэл хамгийн үнэн бодитой мэдлэг бол нэгдүгээр бүлгийн мэдлэг юм. Учир нь тэд рациональ шинжтэй байхын хамт дүн шинжилгээ болон туршилтын үндсэн дээр олж авсан мэдлэг байдаг онцлогтой. Ийм мэдлэг гол төлөв аналитик сэтгүүл зүйн бүтээгдэхүүний үр дүн байдаг юм.

Хоёрдугаар бүлгийн мэдлэг өдөр тутмын шуурхай мэдээллийн сэтгүүл зүйтэй илүү ихээр холбогдоно. Сэтгүүлч өдөр тутмын сурвалжилга, ярилцлагад онолын дүгнэлт, санаа бодлоосоо илүү хувь хүний сэтгэгдэл, үзэл бодол, үнэлэлт дүгнэлтийг сонирхдог. Тийм учраас энэ бүлгийн мэдлэг гол төлөв субъектив шинжтэй байдаг. Тэд утга санааны хувьд олон хувилбартай

байж болох тул эсэргүүцэх, маргаан дагуулах тохиолдол цөөнгүй гардаг. Тиймээс мэдээллийн сэтгүүл зүйд алдаа мадаг гарах, таамаглал дэвшүүлэх, янз бүрийн хувилбарыг санал болгох, эргэлзээ төрүүлэх зэрэг шинж давамгайлдаг. Амьдралын янз бүрийн үзэгдэл, үйл явдлыг тусгахдаа заримдаа баримтыг гуйвуулах тохиолдол гардаг нь үүнтэй холбоотой юм.

Мэдлэгийн гуравдугаар бүлгийн эх сурвалж нь сэтгүүл зүйн нийтлэл-уран сайхны бичлэгийн төрөл, зүйл байдаг. Эссе, уран нийтлэл, найруулал, аян замын тэмдэглэл зэрэг бичлэгийн зүйлд зохиогчийн эргэцүүлэл, үнэлэлт дүгнэлт, үзэл бодол давамгайлсан байдаг. Ийм материалуудад сэтгүүлч тусгаж буй сэдвийг өөрийнхөө ертөнцийг үзэх үзэл, ойлголт, үнэт зүйлийн баримжаа, үнэлэмжийн дагуу илэрхийлдэг. Тиймээс энэ мэдлэг ямагт хувь хүний үзэл бодол давамгайлсан шинжтэй бадаг.

Дээр дурдсанаас үзвэл сэтгүүлчдийн бүтээж буй мэдлэг нь бүтэц бүрэлдэхүүний хувьд эрс тэс ялгаатай гэдэг нь тодорхой байна. Тэднийг “эпистемологийн туйлын зорилгын” үүднээс үнэлж болох уу?

Ямар нэг хэмжээгээр болно. Сэтгүүл зүй зөвхөн мэдээлэхээс гадна харилцан яриа, харилцааны, өөрийгөө илэрхийлэх орон зай, талбар мөн. Энэ утгаар авч үзвэл сэтгүүл зүй “хүний хэмжүүрийн” салбарт ажилладаг. Сэтгүүлч юуны тухай бичсэн ч түүний анхаарлын төвд тусгаж буй объектын тухай хүмүүсийн үнэлэмж, үзэл бодол, тэдний

үйл явдлын талаарх сэтгэгдэл, тэдний үйлдэл, ажил төрөл байдаг. Тэд хамгийн түрүүнд үүнийг сонирхдог. Тиймээс сэтгүүл зүйн эпистемологи судлаачдын бодлоор “рациональ болон субъектив мэдрэмжид үндэслэгдсэн танин мэдэхүйн онол шиг хүнээс хөндийрөх биш, харин танин мэдэхүйн нэгдмэл субъект болох хүнд итгэх итгэл

дээр үндэслэгдсэн байх ёстой” (Микешина Л.А, 2002) юм. Бидний бодлоор “ертөнцийг хамгийн түрүүнд олж хардаг” сэтгүүлчид итгэх итгэл дээр үндэслэгдсэн байх учиртай. Дээр дурдсаныг нэгтгэн үзвэл сэтгүүл зүйн эпистемологийн үндсэн асуудал нь танин мэдэхүйн субъектийн эргэн тойронд төвлөсөн байх шаардлагатай юм.

Бид Монголын сэтгүүл зүйн практикт хийсэн ажиглалт, сэтгүүл

«

Сэтгүүлчдийн бүтээж буй мэдлэг нь бүтэц бүрэлдэхүүний хувьд эрс тэс ялгаатай гэдэг нь тодорхой байна. Тэднийг “эпистемологийн туйлын зорилгын” үүднээс үнэлж болох уу? Ямар нэг хэмжээгээр болно. Сэтгүүл зүй зөвхөн мэдээлэхээс гадна харилцан яриа, харилцааны, өөрийгөө илэрхийлэх орон зай, талбар мөн. Энэ утгаар авч үзвэл сэтгүүл зүй “хүний хэмжүүрийн” салбарт ажилладаг.

»

зүйн танин мэдэхүйн үүргийн талаарх онолын судалгааны үр дүнд тулгуурлан орчин үеийн Монголын сэтгүүл зүйн танин мэдэхүйн үүрэг хангалтгүй, энэ чиглэлээр бичигдсэн нийтлэл, нэвтрүүлгийн чанар, ур чадвар, ач холбогдол тааруу байгаа нь ОНМХ-ийн эзэд, эрхлэн гаргагчид болон сэтгүүлч уран бүтээлчдийн сэтгүүл зүйн мөн чанар, нийгмийн үүрэг, тэр дундаа танин мэдэхүйн үүрэг, боломжийн талаарх онолын ба арга зүйн мэдлэг хангалтгүй байгаатай холбоотой. Сэтгүүл зүй бол нэг талаар, шинж-лэх ухаан, урлагийн нэгэн адил нийгмийн танин мэдэхүйн нэг хэл-бэр, нөгөө талаар, хүний уран бүтээлийн өвөрмөц төрөл бөгөөд энэ хосолмол шинжид түүний мөн чанар оршдог. Сэтгүүлчийн танин мэдэх үйл ажиллагаан дахь дүрслэн бодох болон логикийн нэгдэл нь рациональ ба иррациональ, формаль ба уран бүтээлийн, логикийн ба парадокс шинжийн харьцаагаар тодорхойлогдоно.

Сэтгүүл зүйн танин мэдэхүйн хэв маяг нь үндсэн шинж нь системгүй, өнгөцхөн, зөрчилтэй, өөрийнхөө төсөөлөлд шүүмжлэлгүй ханддаг, зогсонги, хэвшмэл байдаг олон нийтийн ухамсар хэмээх ухамсрын өвөрмөц хэлбэрт үйлчилдэг. Сэтгүүл зүй хүмүүсийн оюуны хүрээнд нэвтрэх тусам хүмүүсийн өдөр тутмын амьдралын талаар түүний оюун санааны хөгжил дэвшил, уналт ухралт, ололт амжилт ба гэмт хэрэг, амьдралын учир утгыг эрж хайх, алдаж онох зэрэг бүхий зүйлийг өөртөө агуулсан олон янзын мэдлэгийн нийлбэрийг бий болгодог.

Энэхүү мэдлэгийг үнэн бодитой, хувийн туршлагад үндэслэгдсэн, субъектив шинжтэй гэсэн гурван бүлэгт хувааж үзэх боломжтой бөгөөд нэгдүгээр бүлгийн мэдлэг нь рациональ шинжтэй, хоёрдугаар бүлгийн мэдлэг нь өдөр тутмын мэдээллийн шуурхай сэтгүүл зүйтэй, гуравдугаар бүлэг нь нийтлэл-уран сайхны бүтээлүүдтэй холбоотой юм.

Эшлэл

1. Свитич Л.Г. 2000. Феномен журнализма. М. Стр. 124.
2. Свитич Л.Г. 2000. Феномен журнализма. М. Стр. 124.
3. Российский энциклопедический словарь. Стр. 30.
4. Российский энциклопедический словарь. Стр. 56.
5. Российский энциклопедический словарь. Стр. 56.
6. Философский словарь. М., 1972. Стр. 411-412.
7. 2000. Основы теории познания (Под ред. Б.И.Липского). СПб. Стр. 4.
8. 2000. Основы теории познания (Под ред. Б.И.Липского). СПб. Стр. 13.
9. Мансурова В.Д. 2002. Журналистская картина мира как фактор социальной детерминации. Барнаул. Стр. 87.
10. Микешина Л.А. 2002. Философия познания. М. Стр. 82.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Баасансүрэн Т. 2020. Монголын чөлөөт хэвлэл ба сэтгүүл зүйн шүүмж судлал, тулгамдсан зарим асуудал. УБ.
2. Галаарид Б. 2018. Монголын чөлөөт хэвлэлийн хөгжил төлөвшил. УБ.
3. Зулькафиль М. 2015-2021. Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд. Боть I-XVIII. УБ.
4. Мансурова В.Д. 2002. Журналистская картина мира как фактор

социальной детерминации.
Барнаул.

5. Микешина Л.А. 2002. Философия познания. М.
6. Норовсүрэн Л. 2007. Монголын нийтлэл. Боть III. УБ.
7. 2000. Основы теории познания (Под ред. Б.И.Липского). СПб.
8. Российский энциклопедический словарь (<http://enc.mail.ru/article>).
9. Свитич Л.Г. 2000. Феномен журнализма. М.
10. Философский словарь. М., 1972. с. 412.

Summary

The purpose of this article is to address the relationship between the nature of journalism and awareness

raising opportunities based on empirical and theoretical research of Mongolian journalism. Using concrete examples, the author explains the reasons for the weak role of Mongolian media in raising public awareness, specifically pointing to the insufficient knowledge of media publishers and journalists about the nature of journalism and its social responsibility as well as their underestimation of journalism's opportunity to raise awareness. The author also explains in detail the epistemological knowledge of journalism, which is important for improving the awareness raising opportunity of journalism, and sheds light on the classification, importance, and the existing gaps of knowledge.